

# БИДИСЕК ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

---

2016 оны 03 сарын 16-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

## *Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай*

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59.4-р заалт болон “БиДиСек ҮЦК” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “БиДиСек ҮЦК” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2016 оны 04 сарын 25- ны өдөр 10 цагт Улаанбаатар хотод “БиДиСек ҮЦК” ХК-ийн өөрийн байранд зарлан хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай.
  - a) Компанийн 2015 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлангийн аудитаар баталгаажсан дүгнэлтийг тайлагнах
  - b) Компанийн 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт бүхий тайланг батлах
  - c) Компани ногдол ашиг тараах эсэх тухай ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг хэлэлцэж батлах
  - d) ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
  - e) ТУЗ-ийн 2016 оны төсөв батлах
  - f) Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай
  - g) Компанийн зарласан болон гаргасан хувьцааны тоог тогтоох тухай
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2016 оны 03 дугаар сарын 28 - ны өдрөөр тогтоосугай.
4. Компанийн ээлжит хурлыг хуралдуулах шийдвэр гарсантай холбогдуулан хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд хурлын зарыг хүргэхээр 2016 оны 03 дугаар сарын 18-ний өдөр тутмын 2-оос доошгүй сонин болон хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр мэдээллэх. Энэ мэдээллийг анх зар хүргэсэн өдрөөс хойш 15 хоногийн

дараа буюу 4 дугаар сарын 2 - ны өдөр дахин зар гаргахыг хурал зохион байгуулах комисст даалгасугай.

5. Ээлжит хурлыг хуралдуулахтай холбогдуулан хурлын дэгийг 01 дүгээр хавсралтаар, хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчид нь энэхүү шийдвэрийн 02 дугаар хавсралтанд заасан бичиг баримттай 2015 оны 03 дугаар сарын 23 - ны өдрөөс хойш 09<sup>00</sup>-18<sup>00</sup> цагийн хооронд “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн байранд ирж танилцах эрхтэй болохыг дурьдсугай.
6. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар санал авах “Саналын хуудас”-ын агуулгыг 03 дугаар хавсралтаар баталсугай.
7. Хувьцаа эзэмшигчээс “Санал авах хуудас”-ыг хүлээн авах сүүлийн өдрийг харъяалагдах брокер, дилерийн компаниар нь дамжуулан хурал хуралдах өдрөөс ажлын 5-с доошгүй хоногийн өмнө байхаар тогтсугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссын гишүүдээр О.Уранбайгаль, Ө.Даваасүрэн, Г.Гэрэлт-од нарыг тус тус томилсугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг удирдах хурлын даргаар Компанийн Дэд захирал Н.Батгэрэл, тооллогын комиссын даргаар Ш.Шинэбаяр гишүүдээр “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн мэргэжилтэн О.Уранбайгаль, Ө.Даваасүрэн нарыг тус тус томилсугай.

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:**



**/Б.ЛХАГВАДОРЖ/**